

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОН

“ГАНЬТ” ХХК-ИЙН

ХООРОНД БАЙГУУЛСАН

**“НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 32 ДУГААР ДУНД СУРГУУЛЬ ТӨСӨЛ”-ИЙН ЗУРАГ
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ-БУУЛГАХ-БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ КОНЦЕССЫН ГЭРЭЭ**

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ

2016 ОН

ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ		2
НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ		2-3
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ	
	Концессын зүйл	3
	Концессын төрөл	3
	Концессын гэрээний хугацаа	3
	Төслийн нийт хөрөнгө оруулалт	4
	Барилгын ажлын хугацаа, баталгаат хугацаа	4
	Гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл	4-5
	Хөрөнгө оруулалтын эргэн төлөлт	5
	Концессын зүйлд тавигдах шаардлага	5
ХОЁРДУГААР БҮЛЭГ	КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ	
	Эрх бүхий этгээдийн эрх, үүрэг	5-6
	Зохицуулах байгууллагын эрх, үүрэг	6
	Концесс эзэмшигчийн эрх, үүрэг	6-7
ГУРАВДУГААР БҮЛЭГ	ЗУРАГ ТӨСӨЛ, БАРИЛГЫН АЖИЛ, БАТАЛГААТ ХУГАЦААН ДАХЬ ЗАСВАР	7-8
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ	КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ	8
	Чанарын хяналт	8
	Баталгаат хугацаан дахь барилга байгууламжийн засварын ажлын хяналт	9
	Санхүүгийн удирдлага, тайлан бүртгэл	9
	Даатгал	9
ТАВДУГААР БҮЛЭГ	ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ	9-10
	Мэдэгдэл	10
	Давагдашгүй хүчин зүйл дуусгавар болох	10
	Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг өөрчлөх, цуцлах	10
ЗУРГААДУГААР БҮЛЭГ	КОНЦЕССЫН ГЭРЭЭГ СУНГАХ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ХАРИУЦЛАГА	10
	Концессын зүйлийг хүлээлгэн өгөх	11
	Хариуцлага	11
ДОЛООДУГААР БҮЛЭГ	МАРГААН ШИЙДВЭРЛЭХ	11
НАЙМДУГААР БҮЛЭГ	БУСАД	
	Хэрэглэх хууль	11
	Нууц хадгалах	12

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Улсын Их Хурлын 2009 оны "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай" 64 дүгээр тогтоол, Концессын тухай хууль, Засгийн газрын 2013 оны "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 243 дугаар тогтоолыг тус тус **ҮНДЭСЛЭН**:

НЭГ ТАЛААС

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР /цаашид "Эрх бүхий этгээд" гэх/;

НӨГӨӨ ТАЛААС

"Ганьт" ХХК /цаашид "Концесс эзэмшигч" гэх/-ийг төлөөлж Захирал Ц.Бат-Эрдэнэ нар энэхүү концессын гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-ээр тодорхойлогдсон эрх, үүрэг, хариуцлагыг харилцан тохиролцон энэхүү Гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний зорилго нь "Нийслэлийн Хан-Уул дүүрэг, 32 дугаар дунд сургууль төсөл"-ийн хүрээнд зураг төслийн дагуу 640 /хүчин чадал/ хүүхдийн сургуулийн барилга байгууламжийг барих төслийг /цаашид "төсөл" гэх/ концессын "зураг төсөл боловсруулах-буулгах-барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхэд Эрх бүхий этгээд, зохицуулах байгууллага болон Концесс эзэмшигчийн хооронд үүсэх бүх төрлийн харилцааг зохицуулахад оршино.

НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

1.1. Энэхүү Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ.

1.1.1. "Концессын зүйл" гэж Нийслэлийн Хан-Уул дүүргийн 32 дугаар дунд сургуулийн хуучин барилгыг буулгах, шинээр барих хүүхдийн сургуулийн барилга байгууламжийг /төслийн нэр/

1.1.2. "Барилгын ажил" гэж сургуулийн барилга байгууламжийг батлагдсан зураг төслийн дагуу барих үйл ажиллагааг;

1.1.3. "Зураг төсөл" гэж барилга байгууламжийг барих эскиз зураг, техникийн болон ажлын зураг, холболтын зураг, инженер-геологийн судалгааны дүгнэлт, геодезийн зураглалыг;

1.1.4. "Талууд" гэж Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигчийг хамтад нь;

1.1.5. "Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч" гэж Концесс эзэмшигчтэй барилгын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан хуулийн этгээдийг;

1.1.6. "Төслийн санхүүжилтийн гэрээ" гэж Концесс эзэмшигч нь хөрөнгө оруулагч, зээл олгогчтой төсөлд оруулах хөрөнгө оруулалт болон эргэн төлөлтийн нөхцөлийн талаар хамтран ажиллахаар тохиролцож байгуулсан гэрээг;

1.1.7. "Эрх бүхий этгээд" гэж төрийн өмчийн концессын зүйлийн хувьд концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг;

1.1.8. "Зохицуулах байгууллага" гэж концессыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох, үнэ тариф тогтоох, концессын зүйл, эсхүл түүгээр үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг батлах, мөрдүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагыг;

1.1.9. "Нийт хөрөнгө оруулалт" гэж энэхүү гэрээний 1.6-д заасныг;

1.1.10. "Нэмэлт гэрээнүүд" гэж энэхүү гэрээний 1.12.2-т заасан тус төсөлтэй холбогдуулан байгуулах нэмэлт гэрээг;

1.1.11. "Гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр" гэж талуудын тохиролцсон хугацааны дотор гэрээний урьдчилсан нөхцөлүүдийг биелүүлсэнээ нотлож Эрх бүхий этгээдэд тайлан ирүүлсэнийг хянан Эрх бүхий этгээд гэрээний урьдчилсан нөхцлийг биелүүлсэнийг хүлээн зөвшөөрсөн өдрийг;

1.1.12. "Ажлын өдөр" гэж долоон өдрийн Бямба, Ням гараг, Монгол Улсын хууль тогтоомжоор тогтоосон нийтээр амрах баяр, ёслолын өдрөөс бусад өдрийг.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Концессын зүйл

- 1.2. Энэхүү Гэрээний концессын зүйл нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:
- 1.2.1. Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 32 дугаар дундсургуулийн барилга байгууламж;
 - 1.2.2. Батлагдсан Зураг төсөл.
- 1.3. Энэхүү Гэрээний 1.2-д заасан концессын зүйлийг Концесс эзэмшигч нь өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр санхүүжүүлэн буулган, барьж, ашиглалтад хүлээлгэн өгөн төрийн өмчид шилжүүлнэ.

Концессын төрөл

- 1.4. Энэхүү Гэрээний концессын төрөл нь "Зураг төсөл боловсруулах-буулгах-барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжинэ.

Концессын гэрээний хугацаа

- 1.5. Энэхүү Гэрээний хугацаа нь Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил байна.

Төслийн нийт хөрөнгө оруулалт

- 1.6. Төслийн нийт хөрөнгө оруулалт нь концессын зүйлийг буулгах, барьж байгуулах, Концесс эзэмшигчийн үйл ажиллагаатай холбогдон гарах бусад зардлуудыг багтаана. Төслийн нийт хөрөнгө оруулалт нь 5,800,000,000.00 /таван тэрбум найман зуун сая/ төгрөг байна. Концесс эзэмшигч нь энэхүү хөрөнгө оруулалтыг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 1.7. Энэхүү гэрээний 1.6-д заасан "Төслийн нийт хөрөнгө оруулалт" гэдэгт цогцолборын бүтээн байгуулалт, түүний дотоод инженерийн холболт, цогцолборт ашиглах газрын хүрээнд гадна талбайн тохижилт, санхүүгийн болон удирдлагын зардал багтана.
- 1.8. Төслийн барилга угсралтын болон шаардлагатай бусад зардлын санхүүжилтийг барилгын ажлын хуваарийн дагуу Монгол улсын аль нэг арилжааны банкин дахь концесс эзэмшигчийн дансанд байршуулж төслийн зориулалтын дагуу зарцуулна.

Барилгын ажлын хугацаа, баталгаат хугацаа

- 1.9. Концесс эзэмшигч нь Нийслэлийн Хан-Уул дүүрэг, 32 дугаар дунд сургуулийн барилга ажлын гүйцэтгэлийн хуваарийн дагуу 2017 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор бүрэн барьж дуусган ашиглалтад хүлээлгэн өгнө. Ашиглалтад хүлээлгэн өгсөн өдрөөс хойш дээрх барилгын баталгаат хугацаа 3 жил байна.
- 1.10. Баталгаат хугацаан дахь сургуулийн барилгын чанараас шалтгаалсан эвдрэл гэмтлийг Концесс эзэмшигч нь өөрийн зардлаар бүрэн хариуцна.
- 1.11. Ашиглалтад хүлээлгэн өгөх үед улсын комиссоос өгсөн хугацаат үүрэг, даалгаврыг концесс эзэмшигч нь бүрэн гүйцэтгэн хүлээлгэн өгнө.



Гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл

1.12. Энэхүү Гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөр Гэрээ байгуулагдсанд тооцогдох бөгөөд тухайн өдрөөс хойш 2 сарын дотор дор дурдсан нөхцөл бүрэн хангагдсанаар Гэрээ хүчин төгөлдөр болно. Үүнд:

1.12.1. Эрх бүхий этгээд болон зохицуулах байгууллагуудын үүрэг:

а. Барилгын ажлын хяналтын зөвлөхийн (цаашид "Хяналтын инженер" гэх) үйлчилгээ үзүүлэх гэрээг Эрх бүхий этгээд Барилгын хөгжлийн төв эсвэл Нийслэлийн хөрөнгө оруулалтын газартай хамтран байгуулах;

б. Концесс эзэмшигч нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тохиолдолд холбогдох тусгай зөвшөөрлүүдийг саадгүй олгох;

Дараах баримт бичгийг Концесс эзэмшигчид өгнө:

в. Засгийн газрын 2016 оны "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 243 дугаар тогтоолыг олгох;

г. Эрх бүхий байгууллагаар магадлагаа хийгдэн батлагдсан /төслийн хүчин чадал/ барилгын иж бүрэн зураг төсөл, техникийн нөхцөлүүд (цахилгаан, холбоо дохиолол, цэвэр бохир ус, дулаан хангамж), хуучин барилга буулгахтай холбоотой зөвшөөрөл, холбогдох бичиг баримтууд.

1.12.2. Концесс эзэмшигчийн үүрэг:

а. Ажлын төлөвлөгөөг Эрх бүхий этгээдээр батлуулах;

б. Төслийн санхүүжилтийн эхний ээлжийн 200,000,000.00 (хоёр зуун сая) төгрөгийг Монгол Улсын аль нэг арилжааны банк дахь өөрийн дансанд байршуулж Төслийн зориулалтын дагуу зарцуулах;

в. Барилга угсралтын ажил гүйцэтгэх гүйцэтгэгчтэй хийсэн гэрээ;

г. Барилга угсралтын ажлын даатгалын гэрээ;

д. Амь нас гэнэтийн ослын даатгалын гэрээ;

е. Хариуцлагын даатгалын гэрээ;

ё. Хуучин барилгыг буулгасан компанитай хийсэн төлбөрийн гэрээ,

1.13. Энэхүү Гэрээний 1.12-д заасан нөхцөл хангагдсан эсэх талаар Эрх бүхий этгээд дүгнэлт гаргана.

1.14. Энэхүү Гэрээний 1.12.1-д заасан үүргээ Эрх бүхий этгээд болон зохицуулах байгууллагууд нь хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд Гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл биелүүлэх хугацааг Эрх бүхий этгээд шаардлагатай хугацаагаар сунгана.

1.15. Энэхүү Гэрээний 1.12.2-т заасан үүргээ Концесс эзэмшигч нь хугацаандаа биелүүлээгүй нөхцөлд Эрх бүхий этгээд нь Гэрээг цуцлах эсэх асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.

1.16. Энэхүү Гэрээний 1.12.2-т заасан нөхцөлөөр гэрээг цуцалсан тохиолдолд Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчид ямар нэгэн нөхөн төлбөр болон хохирлыг төлөхгүй. Концесс эзэмшигчийн буруугаас болж энэхүү гэрээ нь цуцлагдсан тохиолдолд холбогдох зардлыг төр хариуцахгүй.

1.17. Энэхүү гэрээний 1.12.1 болон 1.12.2-т заасан гэрээ хүчин төгөлдөр болох нөхцлүүд бүрэн хангагдсаныг эрх бүхий этгээд дүгнэж Гэрээ хүчин төгөлдөр болсныг Эрх бүхий этгээд Концесс эзэмшигчид албан тоотоор мэдэгдсэн тохиолдолд уг баталгаа нь цуцлагдана.

Хөрөнгө оруулалтын эргэн төлөлт

1.18. Концесс эзэмшигч нь хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг авахдаа 2016 онд тухайн барилгын ажлын гүйцэтгэлийг 50% /тавин хувь/ хийж, 2017 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор барилгын ажлын гүйцэтгэлийг 100% /зуун хувь/ хийж дуусган, ашиглалтад хүлээлгэн өгсөн тохиолдолд дор дурдсан хуваарийн дагуу эргэн төлөлтийг авна. Үүнд:

№	Төлбөрийн дүн /төгрөгөөр/	Төлбөрийн дүн /үсгээр/	Төлбөр гүйцэтгэх он
1	2,900,000,000.00	Хоёр тэрбум есөн зуун сая төгрөг	2016 он
2	2,900,000,000.00	Хоёр тэрбум есөн зуун сая төгрөг	2017 он

- 1.19. Дээр дурдсан хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг 1.18-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд 2016 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IX.2, Концессын төслийн эргэн төлөлт хэсгийн IX.2.1.1-д туссан 5.8 тэрбум төгрөгийг 2016, 2017 онд тус тус эргэн төлнө.

Концессын зүйлд тавигдах шаардлага

- 1.20. Барилга байгууламж нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
- 1.20.1. Зураг төсөл, техникийн шаардлагын дагуу баригдсан байх
- 1.20.2. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм норматив, стандартаар тавигдах бусад шаардлагуудыг хангасан байх
- 1.20.3. Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй барилгын норм стандарт /Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм/-д нийцсэн, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх;

Гэрээний хавсралтууд

- 1.21. Энэхүү гэрээ нь дараах хавсралтуудтай байх бөгөөд хавсралт тус бүр нь гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд:

Хавсралт 1 - Зураг төсөл

Хавсралт 2 – Ажлын тоо хэмжээ

Хавсралт 3 – Барилга угсралтын батлагдсан ажлын төлөвлөгөө

Хавсралт 4 – Төслийн хөрөнгө оруулалтын задаргаа

Хавсралт 5 – Бусад баримт бичгүүд /нийлүүлэх тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, стандарт шаардлага, итгэмжлэлүүд

ХОЁРДУГААР БҮЛЭГ. КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

Эрх бүхий этгээдийн эрх, үүрэг

- 2.1. Эрх бүхий этгээд нь батлагдсан зураг төслийн дагуу барилгын ажилд хяналт тавих хяналтын зөвлөх/цаашид “Зөвлөх” гэх/-ийг ажиллуулна.
- 2.2. Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчийг энэхүү Гэрээнд заасан нөхцөлийн дагуу төслийг хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан зохицуулах байгууллагуудтай хамтарч ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ.
- 2.3. Төслийн нийт хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг энэхүү гэрээний 1.18, 1.19-д заасны дагуу төлж барагдуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.4. Төслийг хэрэгжүүлэх газрыг ямар нэгэн эрхийн зөрчилгүйгээр концессын гэрээний хугацаанд концесс эзэмшигчийн мэдэлд шилжүүлж, эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 2.5. Концесс эзэмшигчид гэрээний дагуу үүргээ биелүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, итгэмжлэлийг цаг хугацаанд нь гаргаж өгөхөд дэмжлэг үзүүлнэ.
- 2.6. Энэ гэрээ болон хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй байлгана.
- 2.7. Концессын тухай хууль болон энэ гэрээгээр хүлээсэн үүргээ мөрдөж ажиллана.

2.8. Концессын зүйлийг анхны зориулалт, хүчин чадлаар нь ажиллуулна.

Зохицуулах байгууллагын эрх, үүрэг

Энэхүү гэрээгээр концесс эзэмшигчийн хүлээсэн үүргийн биелэлтийг хангахад зохицуулах байгууллагууд дараах үүрэгтэй оролцох ба нарийвчилсан эрх үүргийг шаардлагатай тохиолдолд тусгайлсан гэрээгээр зохицуулна.

- 2.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн сургуулийг барьж байгуулах газрыг шилжүүлэн өгсөн байх;
- 2.2. Цогцолборын эскиз зураг, ажлын зургийг баталсан байх;
- 2.3. Барилга байгууламж, хяналт шалгалттай холбоотой хууль, дүрэм журам, норм, стандартаар хангах;
- 2.4. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь төслийг хэрэгжүүлэх ажилд оролцох гадаадын инженер техникийн болон мэргэшсэн ажилчдыг ажиллуулах тусгай зөвшөөрөл олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Засгийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.
- 2.5. Зохицуулах байгууллагууд нь аливаа тусгай зөвшөөрөл олгохдоо үндэслэлгүйгээр удаашруулж, саатуулж болохгүй.
- 2.6. Концесс эзэмшигчид төслийг хэрэгжүүлэхэд нь хэвийн ажиллах нөхцлийг нь бүрдүүлнэ.
- 2.7. Концесс эзэмшигчээс бичгээр гаргасан хүсэлтийг нь үндэслэн шаардлагатай бүх дэд бүтцийг тухайлбал ус, цахилгаан, дулаан, холбоо зэргийг тухайн үеийн тарифаар авах боломжоор хангана.

Концесс эзэмшигчийн эрх, үүрэг

- 2.8. Концесс эзэмшигч нь Монгол улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд байх бөгөөд энэхүү Гэрээний хугацаанд бүртгэл нь хүчин төгөлдөр байж Монгол улсад мөрдөгдөж буй бүх хууль тогтоомж, дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөнө.
- 2.9. Төслийг хэрэгжүүлэх зорилгоор аливаа гуравдагч этгээд, барилгын ажлын ерөнхий болон туслан гүйцэтгэгчтэй хамтран ажиллах нь Концесс эзэмшигчийг Эрх бүхий этгээдийн өмнө хүлээсэн аливаа үүрэг, хариуцлагаас чөлөөлөхгүй бөгөөд Концесс эзэмшигч нь тэдгээрийн үйлдэл, эс үйлдлийн төлөө Эрх бүхий этгээдийн өмнө бүрэн хариуцлага хүлээнэ.
- 2.10. Эрх, үүргийн доголдол, барьцаа өглөггүй концессын зүйлийг Эрх бүхий этгээдэд шилжүүлэн өгөх.
- 2.11. Төслийг хэрэгжүүлэх ажлын явц, баталгаат хугацаан дахь засвар үйлчилгээний ажлын үед ажиллах Монгол инженер техникийн болон мэргэшсэн ажилчдыг сургах асуудлыг хариуцна.
- 2.12. Концесс эзэмшигч нь дараах өөрчлөлтийг Эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.
Үүнд:
 - 2.12.1. Концесс эзэмшигчийн дүрэм, үүсгэн байгуулах тухай шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээ зэрэгт орсон нэмэлт өөрчлөлт;
 - 2.12.2. Төслийн хөрөнгө оруулагч болон төслийн гүйцэтгэгчийг өөрчлөх;
 - 2.12.3. Концесс эзэмшигч нь төслийн санхүүжилтийн гэрээ, барилгын ажил гүйцэтгэх гэрээ, төслийн компанийн хувьцаа эзэмшигчдийн гэрээ зэрэгт нэмэлт, өөрчлөлт орох.



- 2.13. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу концессыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх зөвшөөрлүүдийг авсан байна.
- 2.14. Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах өмчлөлийн эрх, лицензи, материал, арга ажиллагаа, системүүдийг хэрэглэх зөвшөөрлийг авч концессын хугацаанд тэдгээрийг хүчин төгөлдөр байлгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.15. Энэ гэрээний дагуу өөрийн хүлээсэн үүргээ биелүүлэх, үйлчилгээгээ үзүүлэхэд нь Хяналтын инженерт бүх талын туслалцаа үзүүлнэ.
- 2.16. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах үүднээс тэдгээрийн ажилд мониторинг хийж хяналт тавьж ажиллана.
- 2.17. Төслийг хэрэгжүүлэх явцад барилгын ажилтай холбоотой зураг төсөлд тусгагдаагүй аливаа нэмэлт ажлын зардлыг нэмж санхүүжүүлэх тохиолдолд энэ гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдсон зардлыг Эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй бөгөөд энэ нь төслийн нийт хөрөнгө оруулалтын дүнд багтаагүй болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАРИЛГЫН АЖИЛ, БАТАЛГААТ ХУГАЦААН ДАХЬ ЗАСВАР

- 3.1. Концесс эзэмшигч нь концессын зүйлийг барьж байгуулах болон баталгаат хугацаан дахь барилгын чанараас хамаарсан эвдрэл гэмтлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр хийж гүйцэтгэнэ.
- 3.2. Концесс эзэмшигч нь барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэхдээ холбогдох байгууллагаас баталсан барилгын норм норматив, стандартыг дагаж мөрдөнө.
- 3.3. Концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээд эсхүл түүний томилсон аливаа төлөөлөх этгээдэд барилгын ажилтай холбоотой барилга байгууламжид тавих техникийн хяналтын тайлан түүнчлэн Эрх бүхий этгээдийн тухайн үед үндэслэлтэйгээр шаардаж болох бүх мэдээлэл, тайлангуудыг нэмэлт хяналтын гэрээнд заасанчлан гаргаж өгнө.
- 3.4. Эрх бүхий этгээд, зохицуулах байгууллага нь барилгын ажлын аль нэг хэсэг, эсвэл хэсгүүд нь доголдолтой гэж үзэж байгаа бол барилгын ажлын ямар ч үед Концесс эзэмшигчид үндэслэлтэй тайлбар бүхий мэдэгдэл өгч, шаардлагатай бол тухайн хэсгийг нээж, шалгах, доголдолыг засч арилгах шаардлага тавьж болох ба түүнийг Концесс эзэмшигч биелүүлнэ.
- 3.5. Эрх бүхий этгээд, зохицуулах байгууллага нь барилгын ажлын холбогдох хэсгүүдэд үзлэг хийж, доголдолтой гэдэг нь тогтоогдсон бол Концесс эзэмшигч өөрийн зардлаар бүх доголдлыг засч залруулан, үүнтэй холбогдон гарсан бүх үр дүнг хариуцах бөгөөд барилгын ажлын хугацааг үүнтэй холбогдуулж сунгахгүй.
- 3.6. Концесс эзэмшигч нь концессын зүйлийг хүлээлгэн өгөх үед Эрх бүхий этгээд ажлын болон улсын комисс томилон ажиллуулна.
- 3.7. Концесс эзэмшигч нь төслийн газраас үнэт эсхүл эртний эд өлгийн зүйлс, палеонтологи, археологийн олдвор олвол тэр даруй ажлыг зогсоож, Эрх бүхий этгээд болон орон нутгийн удирдлагад мэдэгдэж, тэдний зааварчилгааг биелүүлнэ. Концесс эзэмшигч нь тэдгээр олдворуудыг бусад этгээдүүд ашиглах, гэмтээхээс сэргийлэх шаардлагатай арга хэмжээг яаралтай авна. Энэхүү шалтгааны улмаас цаашид барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон нөхцөлд Эрх бүхий этгээд нь шаардлагатай арга хэмжээг авна.




- 3.8. Эрх бүхий этгээд нь концессын зүйлийг ашиглалтад хүлээлгэн өгөхөөс өмнө барилга байгууламжийг шилжүүлэхэд тавигдах шаардлагыг хангуулах зорилгоор комисс томилон ажиллуулна.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.
КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ**

- 4.1. Эрх бүхий этгээд нь холбогдох төрийн захиргааны байгууллагын төлөөллийг оролцуулан энэхүү Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж болно.
- 4.2. Барилгын ажлыг гүйцэтгэх явцад үзүүлэх хяналтын зөвлөхийн үйлчилгээний зардлыг барилгын ажлын хяналтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 4.3. Концесс эзэмшигч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын төлөвлөгөөг боловсруулж Эрх бүхий этгээдээр батлуулна.
- 4.4. Ажлын төлөвлөгөөг тодотгохдоо үйл ажиллагаа бүрийн явц, үр дүн, тэдгээрийн үйлдэж буй ажлыг гүйцэтгэх хугацаанд үзүүлэх нөлөө болон үйл ажиллагааны дараалалд оруулсан аливаа өөрчлөлтийг тусгана.
- 4.5. Ажлын төлөвлөгөөг батлахдаа Концесс эзэмшигчийн эрх, үүрэг, хариуцлагыг хөндөхгүй.

Чанарын хяналт

- 4.6. Хяналтын инженер Концесс эзэмшигчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар түүнд мэдэгдэх бөгөөд зөрчил, доголдол байж болзошгүй гэж үзсэн болон далд ажлын акт тогтооход Хяналтын инженерийг оролцуулаагүй ажилд зөрчил, доголдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Концесс эзэмшигчид өгөх, туслах эрхтэй.
- 4.7. Концесс эзэмшигч Хяналтын инженерын зардал болон зохиогчийн хяналтын зардал болох барилга угсралтын ажлын төсөвт өртгийн гурав хувьтай тэнцэх төгрөгийг Эрх бүхий этгээдийн заасан дансанд тушаасан байна.
- 4.8. Хэрэв Хяналтын инженер аливаа зөрчил, доголдолтой эсэхийг шалгах зорилгоор техникийн шаардлагад тусгагдаагүй шалгалт туршилт явуулах зааварчилгааг Концесс эзэмшигчид өгч, түүгээр зөрчил, доголдол илэрсэн бол Концесс эзэмшигч шалгалт туршилт явуулсан зардлыг төлнө. Харин зөрчил доголдол илрээгүй бол тийм шалтгалт туршилтын зардлыг болон хариуцлагыг Хяналтын инженер хүлээнэ.
- 4.9. Хяналтын инженер чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө барилгын чанартай холбогдсон зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Концесс эзэмшигчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил доголдлыг арилгаж дуусах хүртэл хугацаагаар сунгана.
- 4.10. Зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Концесс эзэмшигч уг зөрчил, доголдлыг Хяналтын инженерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж Концесс эзэмшигч нь өөрийн зардлаар арилгана.
- 4.11. Хэрэв Концесс эзэмшигч зөрчил, доголдлыг Хяналтын инженерийн мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол инженер зөрчил, доголдол арилгахад шаардагдах зардлыг тооцож зөрчил доголдлыг арилгах тухай мэдэгдлийг Концесс эзэмшигч болон Эрх



бүхий этгээдэд хүргүүлнэ.

Баталгаат хугацаан дахь барилга байгууламжийн засварын ажлын хяналт

4.12. Концесс эзэмшигч нь барилгын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, норматив, стандарт, техникийн баримт бичгийн дагуу баталгаат хугацаан дахь барилга байгууламжийн чанартай холбоотой эвдрэл, гэмтлийн засварын ажлыг өөрийн хөрөнгөөр хариуцан гүйцэтгэж, хэрхэн биелүүлэн ажиллаж байгаад дотоод хяналт тавьж, хяналтын тайланг Эрх бүхий этгээд, Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Санхүүгийн удирдлага, тайлан бүртгэл

4.13. Концесс эзэмшигч нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн Монгол Улсын хууль тогтоомж, стандартын дагуу өөрийн зардлаар гүйцэтгэх бөгөөд төслийн санхүүжилтэд аудит хийх компанийг Эрх бүхий этгээдтэй зөвлөлдсөний үндсэн дээр сонгоно.

4.14. Энэхүү Гэрээний хугацаа дууссан, эсхүл цуцлагдах үед Концесс эзэмшигч нь бүх хяналтын тайлангууд, санхүүгийн тайлан, засварын тайлан зэрэг бичиг баримт болон түүнтэй холбогдолтой бүх материалыг Эрх бүхий этгээдэд ирүүлэх үүрэгтэй.

4.15. Концесс эзэмшигч нь төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон энэхүү Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь нөлөө үзүүлж болох өөрчлөлтийн талаарх шийдвэрийг Эрх бүхий этгээдэд 14 хоногийн дотор мэдэгдэнэ.

Даатгал

4.16. Концесс эзэмшигч энэхүү Гэрээний хэрэгжилтийн үе шат бүрт концессын зүйлийг Концессын тухай хуулийн 26.5-д заасны дагуу гэнэтийн ослын даатгалд хамруулна.

4.17. Энэхүү Гэрээний 4.16-д заасан даатгалын төрөлд даатгуулах үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан бүх зардал, эрсдлийг Концесс эзэмшигч өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

5.1. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэж талуудын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалаагүй, тэдгээрийн хүсэл зориг, хяналтаас гадуур бий болсон, урьдчилан харах боломжгүй буюу талууд өөрсдийн зүгээс зохих шаардлагатай арга хэмжээг авсан хэдий ч урьдчилан сэргийлэх боломжгүй байсан бөгөөд үүний улмаас талуудын үүргийн гүйцэтгэлд саад учруулсан нөхцөл байдлыг хэлнэ. Үүнд:

5.1.1. Үймээн самуун, дайн, халдан довтлох, гадаадаас дайсагнах ажиллагаа, дайн зарласан эсэхээс үл хамааран хийсэн байлдааны үйл ажиллагаа, терроризм буюу алан хядах ажиллагаа, иргэний дайн, бослого, хувьсгал, цэргийн болон бусад хүчийг ашиглан хийх эргэлт бослого, төрийн эрх мэдлийг татан буулгах буюу хүчээр шилжүүлэн авах;

5.1.2. Цацраг идэвхит бодисын тархалт, хордлого, цөмийн болон хорт бодис дэлбэрснээс үүдсэн цацраг идэвхит бодисын тархалт, цөмийн хог хаягдал зэргээс үүссэн бохирдол, бусад аливаа тэсэрч дэлбэрэх болон цөмийн эд материал бодисоос үүссэн аюултай нөхцөл;

5.1.3. Газар хөдлөлт, үер, гал түймэр болон бусад байгалийн гамшиг;

5.1.4. Төслийн үйл ажиллагаа болон газрын ашиглалттай шууд холбоотой тухайлсан тодорхой асуудлаар үүссэн улс үндэстэн, нийтийг хамарсан ажил хаялт, аж үйлдвэрийн болон хөдөлмөрийн маргаан, эсвэл талууд болон тэдгээрийн гүйцэтгэгчид, бэлтгэн нийлүүлэгчдэд ажилладаггүй хөндлөнгийн этгээдийн зүгээс хийж буй ажил хаялт, хөдөлмөрийн маргаан;

- 5.1.5. Барилгын ажлын хуваарь болон байршлыг өөрчлөх хэмжээний ач холбогдолтой өмнө нь мэдэгдээгүй газар орчны нөхцөл байдал, археологийн олдвор болон эртний эд өлгийн зүйлсийг шинээр илрүүлсэн;
- 5.1.7. Энэхүү Гэрээний талуудаас үл хамааран улс төрийн болон эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас энэхүү Гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болох, тэрчлэн Монголын холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрээс болж хөрөнгө оруулалт, барилгын ажлыг зогсооход хүрэх зэрэг саад бэрхшээл учирсан тохиолдолд Гэрээний болон ажил гүйцэтгэх хугацааг хойшлуулах болон сунгах арга хэмжээг Талууд авах болно.
- 5.1.8. Энэхүү Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор бусад этгээдтэй байгуулсан гэрээ хэрэгжихгүй болсон аливаа тохиолдол нь энэхүү Гэрээний 5.1-д зааснаас бусад тохиолдолд гэнэтийн давагдашгүй хүчин зүйлд тооцогдохгүй.

Мэдэгдэл

- 5.2. Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон бол энэхүү Гэрээний дагуу хүлээх эрх, үүргээ биелүүлж чадаагүй буюу боломжгүй болж хойшлогдсон тал нь ажлыг зогсоох эрхтэй байх бөгөөд нөгөө талдаа давагдашгүй хүчин зүйлийн талаарх бүх мэдээлэл болон тухайн үйл явдал нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон болон хугацаа сунгах шаардлагатай болох үндэслэлийн талаар нэн даруй мэдэгдэнэ.

Давагдашгүй хүчин зүйл дуусгавар болох

- 5.3. Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэл дуусгавар болмогц тухайн ашиг сонирхол хөндөгдсөн тал аль болох бололцоотой хугацаанд энэхүү Гэрээний дагуу хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг үргэлжүүлнэ.
- 5.4. Давагдашгүй хүчин зүйл нь тухайн үйл явдал болохоос өмнө үүссэн хариуцлагыг хүлээх эсвэл тухайн үйл явдал болохоос өмнө хугацаа нь болсон төлбөрийн үүргээс чөлөөлөхгүй.

Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг өөрчлөх, цуцлах

- 5.5. Хэрэв гэнэтийн давагдашгүй хүчин зүйл нь 10 өдрөөс илүү хугацаагаар үргэлжилж барилгын ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр бол гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар энэхүү Гэрээний болон барилга барих хугацааг сунгана.
- 5.6. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эсхүл талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс цаашид давагдашгүй хүчин зүйл нь ямар хугацаагаар үргэлжлэх нь тодорхой бус тохиолдолд аль нэг тал нь давагдашгүй хүчин зүйлийн талаарх мэдээлэл хүлээн авснаас хойш 120-оос доошгүй хоногийн өмнө энэхүү Гэрээг цуцалж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ.

КОНЦЕССЫН ГЭРЭЭГ СУНГАХ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ХАРИУЦЛАГА


- 6.1. Концессын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу энэхүү Гэрээний хугацааг сунгах асуудлыг талууд харилцан тохиролцож сунгаж болно.
- 6.2. Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу талууд харилцан тохиролцож энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 6.3. Концессын тухай хуулийн 24-р зүйлд заасны дагуу энэхүү гэрээ дуусгавар болох эсвэл цуцлагдана. Хэрэв Концессын тухай хуулийн 24.2.2, 24.2.3, 22.2.5-д заасан үндэслэлүүдээр цуцлах тохиолдолд:



- 6.3.1. Концесс эзэмшигч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол Эрх бүхий этгээд Концесс эзэмшигчид гэрээг цуцлах тухай мэдэгдэлийг бичгээр хүргүүлсний үндсэн дээр энэхүү концессын гэрээг цуцлах эрхтэй;
- 6.3.2. Концесс эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй нь нотлогдвол Эрх бүхий этгээд Концесс эзэмшигчид энэ талаар дэлгэрэнгүй тайлбарласан концессын гэрээг цуцлах тухай мэдэгдэл хүргүүлнэ;
- 6.3.3. Концесс эзэмшигч мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 өдрийн дотор залруулах хөтөлбөр санал болгох эрхтэй ба [(энэхүү залруулгыг Эрх бүхий этгээдээр зөвшөөрүүлэх ёстой ба зөвшөөрлийг ямар нэгэн шалтгаангүйгээр олгохгүй байх, удаах ёсгүй)] энэхүү хөтөлбөрт хэрхэн залруулах, залруулгыг хэрэгжүүлэхэд ямар хугацаа шаардагдахыг тодорхойтусгана;
- 6.3.4. Хэрэв Концесс эзэмшигч концессын гэрээг цуцлах тухай мэдэгдэлд заасан хугацаанд гэрээг зөрчсөн нөхцөл байдлаа залруулсан эсхүл залруулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бол заагдсан нөхцөл, болзлын дагуу мэдэгдлийг хүчингүй болгож, концессын гэрээг үргэлжлүүлнэ;
- 6.3.5. Хэрэв Концесс эзэмшигч Концессын гэрээг цуцлах тухай мэдэгдэлд заасан хугацаанд гэрээг зөрчсөн нөхцөл байдлыг залруулаагүй [зөвшөөрөгдсөн залруулах хөтөлбөрийн дагуу] эсхүл залруулах хөтөлбөр ирүүлээгүй бол Концессын гэрээг цуцлах тухай мэдэгдэл хүлээж авсанаас хойш 20 өдрийн дараа цуцлагдана;
- 6.3.6. Хэрэв Концесс эзэмшигч залруулах хөтөлбөр санаачилсан ч хэрэгжүүлэхгүй бол Концессын гэрээ нь Концесс эзэмшигчид мэдэгдэл хүргүүлснээс 30 өдрийн дараа цуцлагдана.
- 6.4. Энэхүү гэрээний хүчин төгөлдөр хугацаанд хууль тогтоомж, зураг төсөл өөрчлөгдсөн болон энэхүү Гэрээний 5-р бүлэгт заасан нөхцөл байдал бий болсонтой холбоотой гарах зардал болон ажлын хугацааны нэмэгдэл нь Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл болно.
- 6.5. Концессын хугацаанд Концесс эзэмшигчийн үйл ажиллагаа явуулах орчныг тогтвортой байлгах үүднээс энэхүү Гэрээний 6.3-д зааснаас бусад тохиолдолд энэхүү Гэрээг цуцалж үл болно.

Концессын зүйлийг хүлээлгэн өгөх

- 6.6. Концессын зүйлийг хүлээлгэн өгөх талаар концесс олгогч болон эрх бүхий этгээд шийдвэр гаргасан тохиолдолд тухайн шийдвэрийг үндэслэн концесс олгогч концессын зүйлийг хүлээлцэх комиссыг нэн даруй томилно.
- 6.7. Шийдвэрээр концессын зүйлийг хүлээлгэн өгөх эцсийн хугацаа, комиссын бүрэлдэхүүн, комиссын ажлын удирдамжийг батална.
- 6.8. Комисс концессын зүйлийг хүлээлцэхдээ дараах зарчмыг баримтална:
- төрд буюу концесс олгогч, орон нутгийн өмч, түүнчлэн концесс эзэмшигчийн өмчлөлд үлдэх эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж тодорхойлно;
 - татан буугдсан буюу дампуурсан тохиолдолд концесс эзэмшигчийг дахин хөрөнгөжүүлэх, өөрчлөн байгуулах, эрх үүргийг нь шилжүүлж болох арга хэмжээний төлөвлөгөөг хийж, шийдвэрлүүлнэ;
 - концессын зүйлийн чанар байдалд мэргэжлийн комисс дүгнэлт гаргаж, баталгаажуулна;
 - концессын зүйлийг хүлээлцсэн акт үйлдэж, баталгаажуулна.



Хариуцлага

- 6.9. Концесс эзэмшигч нь Төслийн санхүүжилт болон барилгын ажлыг барилгын ажлын хуваарьт хугацаанаас 2 сараас дээш хугацаагаар ямар нэгэн хүндэтгэх шалтгаангүйгээр саатуулсан тохиолдолд Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээг цуцлах асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.
- 6.10. Энэхүү Гэрээний 6.9-д заасан үндэслэлээр Гэрээг цуцласан тохиолдолд Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчийг шинээр сонгож Төсөлд Концесс эзэмшигчийн зүгээс оруулсан бодит хөрөнгө оруулалтыг тооцон буцаан олгох асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.11. Шинээр сонгогдсон Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 6.10-д заасан Төсөлд оруулсан бодит хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.
- 6.12. Эрх бүхий этгээдийг дараах тохиолдолд гэрээ зөрчсөнд тооцно:
- 6.12.1. Эрх бүхий этгээд, эсхүл аливаа төрийн байгууллага Концессын зүйл ба Концесс эзэмшигчийн хувьцааг албадан хураах, албадан дайчилсан;
- 6.12.2. Концесс эзэмшигчээс бичгээр шаардлага ирүүлсэн өдрөөс 2 (буюу түүнээс дээш) сарын өмнө төлбөрийн хугацаа нь болсон, энэхүү Концессын гэрээний дагуу Эрх бүхий этгээдийн төлбөл зохих төлбөрийг тухайн шаардлага ирүүлснээс хойш 30 өдрийн дотор төлөөгүй бол;
- 6.12.3. Эрх бүхий этгээд энэхүү Концессын гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь Концесс эзэмшигчийн энэхүү Концессын гэрээний дагуу хүлээсэн үүргээ үргэлжилсэн 2 сарын хугацаанд биелүүлэх боломжгүй болгосон.
- 6.13. Эрх бүхий этгээд нь төслийн нийт хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг энэхүү гэрээний 1.18, 1.19-т заасны дагуу төлж барагдуулаагүй тохиолдолд Концесс эзэмшигчид учирсан хохирол, хүүг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 7.1. Энэхүү Гэрээнээс үүдэн гарах аливаа маргааныг шийдвэрлэхдээ Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 7.2. Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигчийн хооронд аливаа маргаан үүсэх тохиолдолд талууд маргааныг эв зүйгээр шийдвэрлэхийг зорино.
- 7.3. Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын Шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ. БУСАД

Хэрэглэх хууль

- 8.1. Энэхүү Гэрээгээр зохицуулагдаагүй аливаа харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шийдвэрлэнэ.
- 8.2. Энэхүү Концессын гэрээгээр талууд хооронд Төсөлтэй холбогдуулан үүссэн бүхий л асуудлуудыг болон гэрээний харилцааг зохицуулна. Энэхүү Концессын гэрээ болон Талуудад үйлчилж буй аливаа Нэмэлт гэрээ хоорондоо зөрчилдөх (үүнд мөн гэрээг тайлбарлахад үүсэх бүхий л асуудлуудыг оролцуулна) тохиолдолд Концессын гэрээ давамгайл үйлчилнэ.



8.3. Энэхүү Концессын гэрээнд хавсаргасан Хавсралтууд нь гэрээний нэг хэсэг бөгөөд хүчин төгөлдөр үйлчлэл бүхий байна. Хэрэв аль нэг Хавсралт дахь агуулга нь Концессын гэрээний агуулгатай зөрчилдөх аваас энэхүү Концессын гэрээний агуулга давамгайлна.

Нууц хадгалах

8.4. Энэхүү Гэрээний 1.6 болон 1.18-д заасан заалт, хөрөнгө оруулалтын болон санхүүгийн мэдээ тайланг Гэрээний нууцад хамааруулна.

8.5. Энэхүү Гэрээний 8.4-д заасан Гэрээний нууцыг талуудын аль нэг нь гуравдагч этгээдэд мэдэгдэх шаардлага үүсвэл нөгөө талаасаа заавал зөвшөөрөл авсан байна.

Энэхүү Гэрээг Талууд Монгол хэлээр 4 хувь үйлдэж, Талууд 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурав.

ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг:

Нэр: С.ЖАВХЛАНБААТАР
Албан тушаал:

Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг
Хөрөнгө оруулалтын газрын дарга

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр
8 давхарт

Холбоо барих утас: 310599

КОНЦЕСС ЭЗЭМЧИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг:

Нэр: Ц.БАТ-ЭРДЭНЭ
Албан тушаал:

“Ганьт” ХХК-ийн Захирал

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
Тээвэрчдийн гудамж-6, “ССS-MGL”
ХХК-ийн байр, 4 давхарт

Холбоо барих: 99111399

